



“МУЗЕЙН НОГООН БАЙГУУЛАМЖ, ТААТАЙ ОРЧИН”
УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Нэг. Зорилго.

Соёлын дэд сайд, ойг тэмдэглэн өнгөрүүлэх Ажлын хэсгийн ахлагч П.Баттөрийн баталсан “Монгол Улсад орчин цагийн музей байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний нэгдсэн удирдамж”-ийн 3.2, төлөвлөгөөний 15 дугаарт тус тус төлөвлөгдсөн музейн үзэгчдийн тэгш хүртээмжтэй байдлыг хангах, таатай орчныг бүрдүүлэхэд чиглэгдсэн дотоод орчны тохижилт, гадаад орчны ногоон байгууламжийг сайжруулахаар хийгдсэн үйл ажиллагааг дүгнэх, шилдэг байгууллагыг шалгаруулахад энэхүү уралдааны зорилго оршино.

Хоёр. Хамрах хүрээ.

Уралдаанд төрийн болон орон нутгийн өмчийн музей, галерей, хувийн өмчийн музей, галерей хамрагдана.

Гурав. Хугацаа.

Уралдааныг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн хооронд зохион байгуулна.

Дөрөв. Уралдаанд оролцоход шаардлагатай бүрдүүлэх материал.

4.1 Оролцогч байгууллага нь дараах материалыг хэвлэмэл буюу цахим хэлбэрээр 2024 оны 5 дугаар сарын 15-ны дотор Түүхэн дурсгалт, барилга архитектурын дурсгалтыг хамгаалах газрын мэргэжилтэн Б.Ариунзаяа (утас 95222424), ariunzaya@ncsch.gov.mn цахим хаягаар ирүүлсний үндсэн дээр тус уралдаанд оролцох эрх үүснэ.

Бүрдүүлэх материал. Үүнд:

- 4.1.1. Газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх тухай захирамж,
- 4.1.2. Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ, гэрээ, газрын кадастрын зураг (зөрчил маргаангүй, хуулийн дагуу байх);
- 4.1.3. Удирдамжийн 7-д заасан 6-н шалгуур үзүүлэлтийн холбогдох мэдээлэл;
- 4.1.4. Гадна болон дотоод орчны тохижилт хийхээс өмнөх (одоогийн) байдлыг харуулсан 8-12 гэрэл зураг (илүү тоотой байж болно).

Тав. Бүтээн байгуулалтад тавигдах шаардлага.

5.1. Оролцогчид музейн гадаад, дотоод орчны тохижилт, ногоон байгууламжийн ажилд дараах Барилгын норм ба дүрэм, стандартыг баримтлана. Үүнд:

- БНБД 30.01.04. Хот, тосгоны төлөвлөлт, Барилгажилтын норм ба дүрэм;
- БНБД 32-01-04. Хот суурины гудамж, зам төлөвлөлт;
- БНБД 3.01.06.90. Барилгын орчны тохижилтын ажил;
- MNS 5973:2009. Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зай;
- MNS 5634:2006. Гар урлал болон урлагийн зориулалттай зүйлс. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага (14.4, 16.5, 16.6 дугаар хэсэг)

5.2. Байгууллагын дотоод орчны тохижилт, ногоон байгууламжийн гүйцэтгэл нь дараах шаардлагыг хангасан байх. Үүнд:

- 5.2.1. Оролцогч байгууллага нь 2024 оны улсын төсөв болон бусад төсөл хөтөлбөрөөр дотоод орчны тохижилт, ногоон байгууламжийн ажлыг гүйцэтгэсэн байх;
- 5.2.2. Эзэмшил газрынхаа 20-30% нь стандартын дагуу мод бут сөөг тарьж зүлэгжүүлэх, цэцгийн мандал, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн байх;
- 5.2.3. Ногоон байгууламжийн арчилгаа, усалгааны асуудлаа шийдсэн байх;
- 5.2.4. Дотоод орчин, үзмэрийн танхим болон гадна талбайн гэрэлтүүлэг шинээр болон нэмэлтээр хийсэн байх;
- 5.2.5. Хаяг тайлбар, цахим болон аудио видео хөтөч түүнтэй адил төстэй үйлчилгээ нэвтрүүлсэн байдал;
- 5.2.6. Авто зогсоол, дугуй, явган зам, орц гарцын тэмдэг тэмдэглэгээ, таних тэмдэг зэргийг байгууллагын онцлог загвараар шийдсэн байх;
- 5.2.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих нөхцлийг шинээр буюу нэмэлтээр бүрдүүлсэн байх.

Зургаа. Шалгаруулалт

- 6.1. Оролцогч байгууллага шалгуур үзүүлэлтийн дагуу ажлын тайланг цаасан хэлбэрээр 2024 оны 9 дүгээр сарын 15-ны дотор Соёлын өвийн үндэсний төвд баталгаат шуудангаар ирүүлнэ.
- 6.2. Соёлын өвийн үндэсний төвийн захирлын баталсан Ажлын хэсэг болон “Музейн ногоон байгууламж, таатай орчин” уралдааныг дүгнэх Дэд ажлын хэсгийн гишүүд оролцогч байгууллагаас ирүүлсэн мэдээ тайланг хэлэлцэн дүгнэж, дүнг гаргана.
- 6.3. Шалгаруулалтыг тухайн оролцогч байгууллагын ирүүлсэн тайланд үндэслэн, гадна болон дотоод орчны тохижилтын ажлын чанарын үзүүлэлт болон бусдад загвар болохуйц, оновчтой, шинэлэг санаачлагыг харгалзана.
- 6.4. Тухайн байгууллага нь дотоод орчны тохижилт, гадна ногоон байгууламжийн ажлаа батлагдсан эскиз зургаар, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн бол давуу тал болно.

- 6.5. Шалгаруулалтыг дүгнэж, шилдэг оролцогчдын шагналыг 2024 оны 11 дүгээр сард зохион байгуулах “Орчин цагийн музей үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хурал-Хүндэтгэлийн арга хэмжээ” дээр гардуулна.

Долоо. Шалгуур үзүүлэлт.

- 7.1. Музей доторх дотоод орчны тохижилт % нэмэгдсэн байдал;
- 7.2. Ногоон байгууламж% нэмэгдсэн байдал;
- 7.3. Авто зогсоол, дугуй, явган зам% нэмэгдсэн байдал;
- 7.4. Гадна, дотоод орчны гэрэлтүүлэг % нэмэгдсэн байдал;
- 7.5. Байгууллагын хаяг болон тэмдэг тэмдэглэгээ % нэмэгдсэн байдал;
- 7.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих нөхцөл % нэмэгдсэн байдал.

Найм. Дүгнэх аргачлал

8.1. Дээрх 6 шалгуур үзүүлэлт тус бүр 0-3 оноогоор дүгнэнэ. Онооны нийлбэр нь 0-6 бол дунд, 7-12 бол сайн, 13-18 бол маш сайн гэж үнэлнэ. Маш сайн үнэлгээ авсан байгууллагуудыг онооны эрэмбээр тэргүүн болон тусгай байранд шалгаруулна.

Жич: Маш сайн үнэлэгдсэн болон оноо тэнцсэн тохиолдолд тохижилтын ажлын чанар үзүүлэлт, оновчтой шинэлэг санаачлагыг харгалзан уралдааныг дүгнэх Дэд ажлын хэсгийн гишүүд санал хураалтаар шийдвэрлэнэ.

Ес. Шагналын сан

Шагналын сан 4.000.000 (дөрвөн сая төгрөг).

Тэргүүн байр – 1. Шагнал 2.000.000 төгрөг

Тусгай байр – 1. Шагнал 1.000.000 төгрөг

Тусгай байр – 1. Шагнал 1.000.000 төгрөг

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:

ТҮҮХЭН ДУРСГАЛТ, БАРИЛГА АРХИТЕКТУРЫН
ДУРСГАЛЫГ ХАМГААЛАХ ГАЗАР

2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

---оОо---